

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ХАРЬЯА БАЙГУУЛЛАГА, ОРОН НУТАГ, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ
АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Б.УРАНЗАЯАГИЙН
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1. ЯАМНЫ АЛБАН ЁСНЫ ЦАХИМ ХУУДАСНЫ ХӨТЛӨЛТИЙГ ХАРИУЦАН ЗОХИОН БАЙГУУЛЖ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ							
1.	Арга хэмжээ 1.1 Байгууллагын бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон цаг үеийн мэдээ мэдээллийг төлөвлөж бэлтгэх, олон нийтэд сурталчлах	Мэдээний тоо	30	35	Мэдээ, мэдээллийн тоо: 140 Яамны албан ёсны цахим хуудсууд болох (фэйсбүүк пэйж, веб сайт)-д: 1. Төрийн захиргааны удирдлагын газраас зохион байгуулсан арга хэмжээний мэдээ- 86 2. Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын- 14 3. Харилцаа холбооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын- 12 4. Кибер аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын- 12 5. Бодлого төлөвлөлтийн газрын- 16 Нийт 140 үйл явдлын мэдээ, материал, постерыг тухай бүр бэлтгэн нийтэлж, хэвлэл мэдээллийн хэрэгслүүд болон олон нийтэд сурталчилж ажилласан.	01-12 сар	100%

2.	Арга хэмжээ 1.2 Удирдлагуудын (Сайд, Дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга)-ын гадаад болон орон нутагт томилолтоор ажилласан ажлын үр дүнгийн талаар мэдээ бэлтгэж сурталчлах	Мэдээний тоо	0	2	Удирдлагуудын гадаад, дотоодод томилолтоор ажилласан талаар нийтэлсэн мэдээний нийт тоо: 62 Сайд Н.Учралын гадаад томилолт: 1. Америкийн Нэгдсэн Улсад айлчилсан айлчлалын мэдээ-2 2. Арабын нэгдсэн Эмират Улсын Дубай хотноо зохион байгуулагдсан “Дэлхийн Засгийн газруудын дээд түвшний уулзалт”-д Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж оролцсон тухай мэдээ-4 3. Бүгд Найрамдах Солонгос Улсад зохион байгуулагдсан “Хиймэл оюун ухаан-Дижитал технологи ба Ардчилал” сэдэвт “Ардчиллын төлөөх дээд хэмжээний уулзалт”-д оролцсон тухай мэдээ-2 Дэд сайд Ж.Эрхэмбаатарын дотоод томилолт: 4. “Цахимд хэвшье” уриатай “Цахим хөгжлийн өдөрлөг” үндэсний хэмжээний арга хэмжээг 21 аймагт бүсчилсэн байдлаар үе шаттай зохион байгуулсан дараах арга хэмжээнүүдийн 4.1.Аймгийн удирдах албан тушаалтан, төрийн албан хаагчид, ЕБС-ийн багш, сурагчид, хувиараа бизнес эрхлэгч иргэд, олон нийтэд зориулсан тусгай хөтөлбөр бүхий сургалт, хичээлүүд 4.2.Мэдээллийн технологийн үндэсний программ хангамж үйлдвэрлэгч компаниудын болон орон нутгийн аж ахуй нэгж, компаниудын бүтээгдэхүүн үйлчилгээний үзэсгэлэн худалдаа, мэргэжлийн багийн зөвлөх үйлчилгээ	01-12	100%
----	--	--------------	---	---	---	-------	------

					4.3.Төрийн үйлчилгээг цахимжуулах шийдэл бүхий төрийн байгууллагын удирдлагууд мэдээллийн технологийн компани хоорондын багийн болон ганцаарчилсан уулзалт, бүтээгдэхүүн үйлчилгээний танилцуулга 4.4.Орон нутгийн жижиг дунд болон хувиараа бизнес эрхлэгчдэд цахим ур чадвар олгох сургалт, технологийн шийдлүүдийн танилцуулга зэрэг олон талт, цогц арга хэмжээнүүдийн фото болон видео мэдээ, рийл нийт-50 Төрийн нарийн бичгийн дарга Б.Батцэцэгийн гадаад томилолт: 5.Испанийн Хаант улсын Барселон хотод болсон Харилцаа холбоо, мэдээллийн технологийн олон улсын хамгийн том арга хэмжээ “Дэлхийн үүрэн холбооны конгресс 2024” арга хэмжээнд оролцсон мэдээ-3 зэрэг нийт 62 мэдээ, материал, постерийг тухай бүр цахим хуудсуудад нийтэлж, веб сайтын кирилл болон монгол бичгийн хувилбарт хөрвүүлэн байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчилж ажилласан.		
3.	Арга хэмжээ 1.3 Байгууллагын цахим хуудас болох (Facebook, Web site)-н хөтлөлтийг хариуцан зохион байгуулж, байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах	Нээлттэй байршуулсан мэдээллийн тоо	0	18	Веб сайтад нээлттэй байршуулсан мэдээ, мэдээллийн тоо: 48 Байгууллагын албан ёсны веб сайт хуудасны үндсэн 6, дэд 60 цэсний мэдээллийг тухай бүр шинэчилж, шаардлагатай мэдээ, мэдээллийг 7 газар, 8 хэлтсээс авч нээлттэй байршуулан, олон нийтийг байгууллагын бодлого, үйл	01-12 сар	100%

				ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллээр тогтмол хангаж ажилласан. 1. 2023 оны жилийн эцсийн өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн тайлан 2. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийн 2023 жилийн эцсийн тайлан 3. "Төрийн цахим мэдээллийн сан хариуцсан байгууллагаас үйлчилгээ үзүүлэх журам" 4. Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд санал авах тухай мэдээлэл 5. "Цагийн бүртгэл хөтлөх, аюулгүй байдлыг хангахад тавигдах шаардлага"-д санал авах тухай мэдээлэл 6. "Хүний эмзэг мэдээлэл, генетик болон биометрик мэдээлэл боловсруулахад баримтлах технологийн аюулгүй байдлын шаардлага, журам"-д санал авах тухай мэдээлэл 7. Эрүүл мэндийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, хадгалах аюулгүй байдлыг хангах журмын төсөлд санал авах тухай мэдээлэл 8. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний программ хангамжид тавигдах шаардлагыг тогтоох, үнэлгээ хийх, шаардлагад нийцсэн программ хангамжийг мэдээлэх журмын төсөлд санал авах тухай мэдээлэл 9. Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөлд санал авах тухай мэдээлэл 10. Яамны сул орон тооны зар нийт 5 удаагийн 13 ажлын байрны сонгон шалгаруулалтын мэдээлэл 11. Албан хаагчдын шинэчилсэн мэдээлэл		
--	--	--	--	---	--	--

				12. Албан хаагчдын "Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг" ХАСУМ 13. "Цахим аймаг" бодлогын зөвлөмж эмхэтгэл 14. Аймгуудын цахим шилжилтийн тайлан 15. Харилцаа холбооны 80 жилийн мэдээлэл 16. Мэдээлийн аюулгүй байдлын аудит хийх зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийн жагсаалт 17. "Шинэ хоршоо хөдөлгөөн" төслийн тоон статистик болон ерөнхий мэдээлэл 18. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөлийн мэдээлэл зэргийг тухай бүр веб сайтад нээлттэй байршуулсан. 19. Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий болон төрийн захиргааны төв байгууллагатай мэдээлэл солилцох, хамтран ажиллах журам 20. Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх журам, аргачлалд санал авах тухай 21. "Хэвлэл мэдээлэл, олон суваг дамжуулах болон цахим орчны үйлчилгээ эрхлэгчийн цахим орчин, өргөн нэвтрүүлгээр түгээсэн контент, мэдээ, мэдээлэл, бүтээл нь хүүхдэд хортой агуулгатай эсэх талаар дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийн ажиллах журам"-ын төсөлд санал авах 22. "Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журам"-ын төсөлд санал авах		
--	--	--	--	--	--	--

				23. "Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх үндэсний зөвлөлийн ажиллах журам"-ын төсөлд санал авах 24. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 364 дүгээр тогтоолоор баталсан "Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сангийн дүрэм", "Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сан бүрдүүлэх, сангийн хөрөнгийг зарцуулах журам"-д оруулах нэмэлт өөрчлөлтийн төсөлд санал авах 25. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас Радио долгионы тухай хуулийн 5.2.6 заалтыг үндэслэн "Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт"-ийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд Дэлхийн Радио Холбооны их хурал (WRC-23)-ын шийдвэрийн дагуу холбогдох өөрчлөлтийг тусган санал авах 26. "Мэдээллийн технологийн үндэсний парк"-ийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийсэн ажлын тайлан 27. "Радио телевизийн үндэсний сүлжээ" утүг-ын үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийсэн ажлын тайлан 28. "И-монгол академи" утүг-ын үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийсэн ажлын тайлан 29. Цахим хөгжил, харилцаа холбооны яамны чиг үүрэгт хамаарах хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийн 30. Сайд, төрийн нарийн бичгийн даргын "А" ангиллын тушаалын хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан		
--	--	--	--	--	--	--

				31. Яамны "Ил тод байдлын шалгуур үзүүлэлт"-ийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийсэн тайлан 32. Яаманд хамаарах хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлан 33. Яамны сургалт, нийгмийн баталгааны хөтөлбөрийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлан 34. "Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө"-ний IV улирлын хэрэгжилтийн тайлан 35. "Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар"-ын 2023, 2024 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлан 36. Монгол улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн яамны хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлан 37. Яаманд хамаарах "хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт"-д хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлан /2024 эхний хагас жил/ 38. "Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 2024 оын II улирлын хэрэгжилтийн тайлан 39. "Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө"-ний эхний хагас жилийн хэрэгжилтийн тайлан-2024 40. "Ил тод байдлын шалгуур үзүүлэлт"-ийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлан-2024 41. Сайдын эрхлэх асуудлын хүрээний стратеги төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлан-2024		
--	--	--	--	--	--	--

					42. ЦХИХХЯ болон харьяа байгууллагуудын 2024 оны I улирлын өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн тайлан 43. ЦХИХХЯ болон харьяа байгууллагуудын 2024 оны эхний хагас жилийн өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн тайлан 44. Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн тайлан 2024 оны III улирал 45. Төрийн жинхэнэ албан хаагчийг шилжүүлэх, сэлгэн ажиллуулах тухай зар, мэдээлэл нийт 5 удаа 46. Салбарын хяналт, шалгалтын мэдээлэл 47. 2025 оны Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санал 48. “Төр, хувийн хэвшлийн түншлэл” нээлттэй уулзалтын хүсэлт зэрэг мэдээллийг тухай бүр нээлттэй байршуулсан.		
4.	Арга хэмжээ 1.4 Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу олон нийтэд байнга, нээлттэй, ил тод байлгах мэдээллийг байршуулах	Мэдээллийн тоо	50	68	Байршуулсан мэдээллийн тоо, үнэлгээ: 68 мэдээ, 98% үнэлэгдсэн. Байгууллагын албан ёсны цахим веб сайт https://mddc.gov.mn/mn/ хуудсанд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан “Хаалттай”, “Хязгаарлалттай” гэж зааснаас бусад нээлттэй байршуулах шаардлагатай 68 төрлийн мэдээллийг (Яамны мэдээлэл хариуцагч газар, хэлтэс, албан хаагчдын жагсаалт бүхий Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн А/21 тушаал гарсан) олон нийтийн мэдэх эрхийг хангах хүрээнд тухай бүр ил тод, нээлттэй байршуулж ажилласан. Хэрэгжилтийн явц 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар shilen.gov.mn https://shilen.gov.mn/ сайтад 98% үнэлэгдсэн.	01-12 сар	100%

5.	Арга хэмжээ 1.5. Байгууллагын албан ёсны цахим хуудасны мэдээллийг монгол бичгийн хувилбарт тухай бүр хөрвүүлж, нийтлэх	Мэдээний тоо	30	35	Монгол бичигт хөрвүүлсэн мэдээний нийт тоо: 140 Байгууллагын веб сайт хуудсыг монгол бичигт хөрвүүлэх ажил 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр бүрэн дуусаж, үндсэн 5, дэд 40 цэсний мэдээллүүд тухай бүр монгол бичгээр олон нийтэд хүрч эхэлсэн. 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдөр буюу 2024 оны жилийн эцсийн байдлаар веб сайтын монгол бичгийн хувилбарт https://service.gov.mn/ нийт 140 мэдээ хөрвүүлж нийтэлсэн байна.	01-12	100%
----	---	--------------	----	----	--	-------	------

Зорилт 2. САЙДЫН АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА НАРТАЙ 2024 ОНД ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ БАЙГУУЛАХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ХАРЬЯА БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨГ БАТЛУУЛЖ, БИЕЛЭЛТИЙГ ХШУДАГ-Т ХҮРГҮҮЛЖ ҮНЭЛҮҮЛЭХ

1.	Арга хэмжээ 2.1. Сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудын үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж, биелэлтийг хагас, бүтэн жилээр авч ХШУДАГ-т хүргүүлэн, үнэлүүлэх ажлыг зохион байгуулах	Төлөвлөгөө, тайлангийн тоо	3	4	Батлуулсан төлөвлөгөө, тайлан: 4 Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар болон "И-Монгол" академи УТҮГ, "Үндэсний дата төв" УТҮГ, Радио, телевизийн үндэсний сүлжээ" УТҮГ-ын 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг нэгтгэн авч сайдаар батлуулан холбогдох газруудад хүргүүлсэн. Харьяа байгууллагуудын 2024 оны эхний хагас жилийн тайланг нэгтгэн авч ХШУДАГ-т хүргүүлсэн. Бүтэн жилийн үйл ажиллагааны тайланг 12 дугаар сарын 20-ны дотор нэгтгэн авч, ХШУДАГ-т хүргүүлж, үнэлүүлэхээр ажиллаж байна.	02, 06, 12 сар	100%
2.	Арга хэмжээ 2.2. Сайдын аймаг, нийслэлийн Засаг дарга нартай 2024 онд хамтран ажиллах гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах, биелэлтийг бүтэн	Гэрээний тоо	22	22	Байгуулсан гэрээний тоо: 22 Сайдын нийслэл болон 21 аймгийн Засаг дарга нартай 2024 онд хамтран ажиллах гэрээ байгуулах ажлыг зохион байгуулж, яамны газар, хэлтсүүд, харьяа байгууллагууд,	01, 12 сар	100%

	жилээр авч, ХШУДАГ-т хүргүүлж дүгнүүлэх.				нийслэл, 21 аймгаас санал авч нэгтгэн төслийг эцэслэж, 44% хэвлэн гэрээлэх өдөр буюу 2024.01.31-ний өдөр холбогдох удирдлагуудаар гарын үсэг зуруулан баталгаажуулсан. Биелэлтийг гэрээнд заасны дагуу 2024 оны 12 дугаар сарын 25-ны дотор нэгтгэн авч, ХШУДАГ-т үнэлүүлэхээр ажиллаж байна.		
Зорилт.3 “ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ”							
1.	Арга хэмжээ 3.1. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон холбогдох журамд заасны дагуу албан бичиг боловсруулах, шийдвэрлэх, Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад заасан баримт бичгийг аривт хүлээлгэн өгөх	Албан бичиг хүргүүлсэн, шийдвэрлэсэн эсэх Архив өгсөн эсэх Тийм-1, Үгүй-1	0	1	Цахим архив:1 Цаасан архив:3 1.2023 оны зургийн сан болон мэдээний файлыг 1 терабайт хаардад цахим архив үүсгэн архивласан. 2.Сайдын аймаг, нийслэлийн Засаг дарга нартай 2023 онд хамтран ажиллах гэрээ 3. Харьяа байгууллагуудын 2023 оны үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөө 4. Харьяа байгууллагуудын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, тайлан нийт 3 хадгаламжийн нэгж архивлаж, архив, бичиг хэрэгт хүлээлгэн өгсөн.	05 сар	100%
	Арга хэмжээ 3.2. Чиг үүргийн дагуу удирдлагаас өгсөн үүрэг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт болон шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх	Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн биелэлтийн тоо Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн	0	1	Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн биелэлт:1 1. ЗГХЭГ-ын 374-р тогтоолын хэрэгжилт буюу “Ил тод байдлын шалгуур үзүүлэлт”-ийн биелэлтийг хугацаанд нь 100%-ийн гүйцэтгэлтэй тайлагнаж, ХШУДАГ-аар үнэлүүлэн хүргүүлсэн. Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийн тоо: 10 2. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилт, ЗГХЭГ-ын Хууль тогтоомж, тогтоол	01-12	100%

		биелэлтийн тоо			шийдвэрийн биелэлтэд байгууллагын албан ёсны веб сайт хуудасны Монгол бичгийн хувилбарын хөтлөлт, хөрвүүлэлт, биелэлтийг сар бүр хугацаанд нь тайлагнаж ажилласан. 3. Удирдлагаас цохсон 48 албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэсэн.		
--	--	----------------	--	--	---	--	--

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1.	1. Байгууллагын нийт хурал, уулзалтын мэдээллийг нэгтгэж, холбогдох албан хаагчдыг мэдээллээр хангах	Хурал, уулзалтуудын тоо	0	148	Нийт нэгтгэсэн хурал, уулзалтын тоо: 318 7 хоногт- 14 хурал, уулзалт Сард -28 хурал, уулзалт 2024 оны 01 дүгээр сараас 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар нийт 318 хурал, уулзалтын мэдээлэл нэгтгэсэн байна.	01-12 сар	100%
2.	2. Төрийн захиргааны удирдлагын газрын 7 хоногийн тайлан нэгтгэх	Нэгтгэсэн тайлангийн тоо	0	12	Нэгтгэсэн тайлангийн тоо: 16 Төрийн захиргааны удирдлагын газрын 7 хоног бүрийн тайланг нэгтгэж, холбогдох мэргэжилтэнд тухай бүр хүргүүлсэн.	01-04 сар	100%
3.	3. Хурлын зүүм эрх үүсгэх	Зүүм эрх үүсгэсэн тоо	-	-	Эрх нээсэн зүүм хурлын тоо: 8 Техник, сүлжээ, программ хангамж хариуцсан мэргэжилтэнг БНСУ руу сургалтаар явсан хугацаанд 8	05 сар	100%

					хурал, уулзалтын зүүм эрх нээж ажилласан.		
4.	4.“Засгийн газрын цом-2024” тэмцээнд оролцох	Тэмцээний төрөл, тоо	0	4	“Засгийн газрын цом-2024” тэмцээнд спортын “Шатар”, “Сагсан бөмбөг”, “Гар бөмбөг”, “Теннис” 4 төрөлд амжилттай оролцож, шатрын төрөлд 1-р байранд шалгарч, “Шилдэг эмэгтэй тоглогч”, “Алтан медаль”, Монгол Улсын Засгийн газрын шагнал “Биеийн тамир, спортын тэргүүний ажилтан” хүндэт тэмдгээр шагнуулсан.	11,12 сар	100%

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт


Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 1. Удирдлагын Академийн “Төрийн албан хаагчийн богино, дунд хугацааны сургалтын хөтөлбөр”-т хамрагдах	Дунд хугацааны сургалт	Дунд хугацааны мэргэшүүлэх /06 сар/ сургалтад хамрагдсан	-	1.Төрийн албаны зөвлөлөөс 7 хоног бүр тогтмол зохион байгуулдаг Төрийн албан хаагчийн “7:4:10 сургалт” нийт 40 удаагийн сургалт 2.”Мэдээллийн хүртээмжийн тэлэлт ба Төрийн үйл ажиллагаанд оролцох нь” сэдэвт мэдээллийн хүртээмжийг хэрэгжүүлэх бодлогын уялдааг хангахад төр, хувийн хэвшлийн түншлэл, тэдгээрийн оролцоог хангах олон талт сургалт	01-12	

					3.ЮНЕСКО-гийн “Хэвлэл мэдээллийг хамгаалах олон улсын сан”-гийн дэмжлэгтэйгээр Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний төлөө хуульчдын сүлжээг бэхжүүлэх төслийн хүрээнд зохион байгуулагдсан “Хэвлэл мэдээллийн эрх зүйн форум” 4.”Жендэрийн мэдрэмжтэй сэтгүүл зүй” яамдын хэвлэлийн төлөөлөгчдийн оролцоот сургалт		
--	--	--	--	--	--	--	--

ТАЙЛАН ГАРГАСАН:

Харьяа байгууллага, орон нутаг, хэвлэл, олон нийттэй харилцах мэргэжилтэн

(Албан тушаал)

Б.Уранзаяа /  /

(Нэр, гарын үсэг)

2024.12.05

(Огноо)